

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгсийн жагсаалт	1
ҮАГ-ын хоёрдугаар газар		
<i>Захирал</i>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	2
<i>Ц.Батбаяр</i>		
<i>Аудитын менежер</i>		
<i>Х.Баярмаа</i>	Бүлэг 1 Тендерийн хууль зөрчигдсөн байна	
<i>Ахлах аудитор</i>		
<i>С.Сэрчхорол</i>		
<i>Шинжээч Д.Баттулга</i>		
2008 оны 6 дугаар сар	<ul style="list-style-type: none">• Хууль зөрчин тендерт оролцуулсан байна	3
	<ul style="list-style-type: none">• Үнэн зөв шалгаруулаагүй байна	4
Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:	Бүлэг 2 Хөтөлбөр хугацаандаа хэрэгжих боломжгүй болжээ	
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	<ul style="list-style-type: none">• Хөтөлбөр хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна	5
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533, 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<ul style="list-style-type: none">• Гэрээний явцын хяналт дутмаг байна	6
ХАЯГ:	<ul style="list-style-type: none">• Сургалтад хамрагдсан англи хэлний багш нарын мэдлэг хангалтгүй байна	6
<i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	<ul style="list-style-type: none">• Хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилт өөрчлөгджээ	7
	<ul style="list-style-type: none">• Дүгнэлт	7
	<ul style="list-style-type: none">• Зөвлөмж	7
	<ul style="list-style-type: none">• Холбогдох байгууллагын санал	8-10
	<ul style="list-style-type: none">• Тайлбар	11

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЯ	Сангийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
МАХБНХ	Монголын англи хэлний багш нарын холбоо
ГХСТХ	Гадаад хэлний сургалтын төвүүдийн холбоо
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо технологийн газар
МХС	Мэдээлэл холбооны сүлжээ
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ZZ	Зөвлөх үйлчилгээ
ТТ	Тоног төхөөрөмж
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны саналыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Мэдээллийн технологийн чиглэлээр англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах хөтөлбөрийн бараа, ажил үйлчилгээний сонгон шалгаруулалт, түүний үр дүнг шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитаар дараахь асуудлыг авч үзэв. Үүнд:

- Тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;

Аудитад дор дурдсан арга зүйг ашиглалаа. Үүнд:

- БСШУЯ-нд тендер зохион байгуулсан үйл ажиллагаатай танилцах;
- СЯ болон БСШУЯ-ны холбогдох ажилтнуудаас судалгаа, тодруулга авах;
- Тендерт оролцсон болон шалгарсан байгууллагуудын ажилтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, үр дүнг хэрэгжүүлж байгаа газруудад түүвэрчлэн шалгах;
- Хөтөлбөрт хамрагдсан ерөнхий боловсролын сургуулиудаас түүвэрчилж судалгаа авах, тоног төхөөрөмжийн техникийн хүчин чадлыг гэрээнд тусгагдсаны дагуу нийлүүлсэн эсэхийг шалгах;
- Хөтөлбөрт хамрагдаж сургалтад оролцсон багш нараас судалгаа авах;


Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

ТЕНДЕРИЙН ХУУЛЬ ЗӨРЧИГДСӨН БАЙНА

1.1 Монгол Улсын 2007 оны төсвийн тодотголоор Мэдээллийн технологийн чиглэлээр англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах хөтөлбөрт 5,7 тэрбум төгрөг баталж, БСШУЯ хэрэгжүүлэхээр тусгажээ.

1.2 Дээрх хөрөнгөөс 4,0 тэрбум төгрөгийг англи хэлний сургалтын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад, 1,7 тэрбум төгрөгийг зөвлөхийн үйлчилгээнд зарцуулахаар заасан байна.

Графикаар харуулбал:



Хууль зөрчин тендерт оролцуулсан байна

1.3 БСШУЯ Мэдээллийн технологийн чиглэлээр англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах хөтөлбөрийн төслийн баримт бичгийг ГХСТХ, МАХБНХ, “Дайнид Монгол” ХХК-тай хамтран боловсруулсан байна.

1.4 Улмаар хөтөлбөрийн төслийн баримт бичиг боловсруулсан дээрх байгууллагуудыг тендерт оролцуулжээ.

1.5 Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1.5-д “Тендерт оролцогч нь бараа, ажил, үйлчилгээний зураг, төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой” нь тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ гэж заасныг зөрчсөн байна.

Үнэн зөв шалгаруулаагүй байна

1.6 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 28.1-д ...“Шаардлагад нийцсэн гэж үзсэн бүх тендерт үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу тендерийг хосолмол аргаар шалгаруулсан байна.

Тендер шалгаруулалтын дүнг хүснэгтээр харуулбал: (сая төгрөгөөр)

Д/д	Тендерийн нэр	Тендер зарласан огноо	Хөтөлбөр хэрэгжих хугацаа	Захиалагчийн үнэ	Тендерийн ялагч	Ялагчийн үнэ
1	Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх төслийн санал бэлтгэх судалгаа (ZZ-2007-02)	2007.11.08	2007.12.13-2008.01.31	195.5	МАХБНХ	165.5
2	Англи хэлний багш бэлтгэдэг сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх сургалт (ZZ-2007-04)	2007.11.08	2007.12.13-2007.01.31	200.0		
3	Мэдээллийн технологи ашиглан англи хэл заах арга зүйг эзэмшүүлэх сургалт (ZZ-2007-03)	2007.11.08	2008.01.01-2008.06.31	195.7	Дайнид Монгол ХХК	195.6
4	ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт (ZZ-2007-01)	2007.11.08	2007.12.01-2008.06.31	1.122.4		
5	Англи хэлний сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх (ТТ-2007-27)	2007.10.22	2007.12.25-2008.04.25	4.000.0	MCS электроникс ХХК	3.969.2

1.7 БСШУЯ-ны тендерийн үнэлгээний хороо зөвлөх үйлчилгээний ZZ-2007-01 багцыг үнэлж “Непко” ХХК-ийг шалгаруулжээ.

1.8 Уг тендерийн материалыг Сангийн яам хянан үзэж, БСШУЯ-ны үнэлгээний хорооны дүгнэлтийг “техникийн үнэлгээг үнэн зөв хийж чадаагүй” гэсэн үндэслэлээр Сангийн сайдын 2008 оны 9-11/02 албан тоотоор ГХСТХ-той гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон байна.

1.9 “Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх багц төслийн санал бэлтгэх, арга зүйг боловсронгуй болгох судалгаа” II багцад МАХБНХ, “Мэдээллийн технологи ашиглан англи хэл заах арга зүйг эзэмшүүлэх сургалт” III багцад “Дайнид Монгол” ХХК-иуд шалгарсан тул Сангийн яамнаас тендерийн материалыг хянан үзэж гэрээ байгуулах эрх олгожээ.

1.10 Харин “Англи хэлний багш бэлтгэдэг сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сертификатжуулах ажил” IV багцын тендерт оролцсон МАХБХ-ны үнийн санал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 30.1.3 -т заасанчлан “захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн” тул яамны үнэлгээний хороо тендерийг хүчингүй болгосон байна.

Мэдээллийн технологийн чиглэлээр англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах хөтөлбөрийн бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалт

ХӨТӨЛБӨР ХУГАЦААНДАА ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ БОЛЖЭЭ

Хөтөлбөр хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна

2.1 БСШУЯ “MCS электроникс” ХХК -тай 2007 оны 12 дугаар сарын 20-нд англи хэлний тоног төхөөрөмж нийлүүлэх ТТ-2007-27 тоот гэрээ байгуулжээ.

2.2 2008 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тоног төхөөрөмжийг нийлүүлж, интернэтийн холболтыг 2008 оны 4 дүгээр сарын 30-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээнд тусгажээ.

2.3 Гэтэл “MCS электроникс” ХХК нь 5 дугаар сарын 15-ны байдлаар принтер болон дагалдах хэрэгслийг бүрэн нийлүүлж дуусаагүй байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Гэрээнд заасан хугацаа	Тоо ширхэг	Нийлүүлсэн хугацаа	Дутуу байгаа ажил үйлчилгээ
1	Компьютер, дагалдах хэрэгслийн хамт	2008.01.20	4032	2008.01.29 нээс 4.04.	
2	Принтер	2008.01.20	192	2008.3.20-ноос 5.10	50
3	Проектор дэлгэцийн хамт	2008.01.20	192	2008.01.29 нээс 4.04.	
4	Интернэттэй холбох	2008.4.30	173	5.15-ны байдлаар 64 сургууль	109
5	Дотоод сүлжээ	2008.4.30	173	5.15-ны байдлаар 79 сургууль	94

2.4 Гэрээнд заасны дагуу УБ хотын ерөнхий боловсролын 80 сургуулиас 64 сургуулийг ADSL модемоор интернэтийн сүлжээнд холбожээ.

2.5 Харин орон нутгийн 93 сургуулийг интернэтэд холбох ажил дараахь байдалтай явагдаж байна. Үүнд:

- ❖ 8 аймгийн нийт 49 сургуулийн дотоод сүлжээг зохион байгуулж, интернэтэд холбогдоход шаардлагатай ажлуудыг гүйцэтгэсэн боловч БСШУЯ МХС ХХК-тай (Е1 сүлжээ) түрээслэх гэрээ байгуулаагүй учраас хүлээгдэж байна.
- ❖ Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудад шилэн кабель татах ажил дуусах шатандаа явагдаж, Архангай, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудад шилэн кабель татах бэлтгэл ажил хийгджээ.

2.6 Хөтөлбөрт хамрагдсан сургуулиудын хувьд интернэтэд бүрэн холбогдоогүй, холбогдсон нь ачааллаа даахгүй, зарим нь бүр холбогдох боломжгүйгээс хөтөлбөр бүрэн хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна.

2.7 “Англи хэлний сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл хугацаандаа хэрэгжээгүй, интернэтийн сүлжээ бүрэн холбогдоогүйгээс шалтгаалж, ихэнх сургуулиудад англи хэлний Онлайн сургалт явуулах боломжгүй болжээ.

Гэрээний явцын хяналт дутмаг байна

2.8 БСШУЯ-ны ТНБД англи хэлний сургалтын тоног төхөөрөмжийн худалдан авалт, англи хэлний сургалтын кабинетыг шалгах ажлын хэсгийг 2008 оны 107 дугаар тушаалаар байгуулсан боловч өнөөг хүртэл шалгаж, ажлын тайлангаа гаргаж өгөөгүй байна.

2.9 “MCS электроникс” ХХК гэрээнд заасан хугацаандаа тоног төхөөрөмж нийлүүлэх, интернэтийн сүлжээнд холбох боломжгүй болсон тул гэрээг 2 тал 6 дугаар сарын 15-ныг хүртэл сунгажээ.

2.10 БСШУЯ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний явцыг хянаж дүгнээгүй байна.

Сургалтад хамрагдсан англи хэлний багш нарын мэдлэг хангалтгүй байна

2.11 ZZ-2007-03 хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Дайнид Монгол” ХХК “Мэдээллийн технологи ашиглан англи хэл заах арга зүйг эзэмшүүлэх сургалт” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 192 сургуулийн англи хэлний багш нарт мэдээллийн технологи ашиглан англи хэл заах арга зүйг эзэмшүүлэх сургалтыг 2008 оны 2 дугаар сарын 14-28 хүртэл 14 хоногийн хугацаатай зохион байгуулжээ.

2.12 Дайнид Монгол ХХК сургалтад хамрагдсан багш нараас сургалт эхлэхийн өмнө англи хэлний түвшин тогтоох шалгалт авахад дундаж нь 0,8 оноо авсан байна.

2.13 Сургалт явуулж дууссаны дараа дахин шалгалт авахад дундаж нь 1,0 оноо болж өмнөхөөсөө 0,2 пунктээр ахисан боловч энэ нь англи хэлний түвшин тогтоох олон улсын стандартын анхан шатны түвшин (англи хэлээр цөөн тооны хэллэгүүдийг ярьж ойлгох, энгийн асуултад богино хариулт хэлж чадна)-д байгаа нь багш нарын мэдлэгийн түвшин хангалтгүй байгааг харуулж байна.

2.14 Аудит хийх явцад дээрх сургалтад хамрагдсан зарим багш нараас “мэдээллийн технологи ашиглан англи хэл заах нь сургалтын уламжлалт арга хэлбэрээс илүү үр дүнтэй байна уу” гэсэн асуултаудад 98 хувь нь “**тийм**” гэсэн хариулт өгчээ.

Хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилт өөрчлөгджээ

2.15 Хөтөлбөр 2007-2008 оны хичээлийн жилд 174 сургуулийн төгсөх 11 дүгээр ангийн 6960 сурагчдад Энэтхэг улсын NIIT, Artech зэрэг мэдээллийн технологийн сургуулиудын элсэлтийн шалгалтын англи хэлний болзлыг хангахуйц буюу ойролцоогоор TOEFL-ийн 500 онооны англи хэлний мэдлэг эзэмшүүлэх зорилт дэвшүүлэн тавьжээ.

2.16 БСШУС-ын 2007 оны 381 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын 192 сургуулийн англи хэлний багш нарыг мэдээллийн технологи ашиглан англи хэл заах, багш бэлтгэдэг их, дээд сургуулийн 75 багш болон ерөнхий боловсролын 1961 багшид англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулахаар өөрчилсөн байна.

2.17 Энэ нь БСШУЯ-наас уг хөтөлбөрийг шууд хэрэгжүүлэхийн тулд англи хэлний багш нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэдээллийн технологи ашиглан англи хэл заах арга зүй эзэмшүүлэх шаардлагатай болсонтой холбоотой гэж үзжээ.

2.18 Хөтөлбөрт боловсролын үйлчилгээний цахим тогтолцооны дэд бүтцийн суурийг тавих, цахим мэдээллийн үйлчилгээг бий болгох, хүний нөөцийн чадавхи дээшлүүлэх стратеги баримтлахаар заасан байна.

2.19 Дээрх хөтөлбөрийн дагуу 2007-2008 оны хичээлийн жилд 11 дүгээр ангийн сурагчид хамрагдах байсан боловч БСШУЯ-ны бага, дунд боловсролын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Н.Энхбат 2008 оны 3/931 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын дарга нарт мэдээллийн технологид суурилсан англи хэлний сургалтад 9 болон 11 дүгээр ангиас бусад ангийн англи хэл сурах сонирхолтой сурагчдыг сонгож суралцуулахыг даалгажээ.

2.20 Ийнхүү хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилтыг БСШУЯ дур мэдэн өөрчилсөн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна Үүнд:

- ❖ Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний мэргэжил дээшлүүлэх сургалт ZZ-2007-01 тендерийн үнэлгээг үнэн зөв хийж сонгон шалгаруулж чадаагүй байна.
- ❖ “MCS электроникс” ХХК нь бараа, ажил, үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд бүрэн нийлүүлээгүй байна.
- ❖ Хөтөлбөрийн анхны дэвшүүлсэн зорилт өөрчлөгджээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав нарт :

- “ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэшил дээшлүүлэх сургалт”, “Англи хэлний багш бэлтгэдэг сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сертификатжуулах ажил” төслүүдийн техникийн нөхцөлийг дахин боловсруулж, хуулийн хүрээнд тендерийг зарлан сонгон шалгаруулах;
- “MCS электроникс “ ХХК, МАХБНХ, “Дайнид Монгол” ХХК-тай байгуулсан гэрээний явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 32-31-58
E-mail: mecs@mecs.pmis.gov.mn
Web address: http://mecs.pmis.gov.mn/

2008.06.12 № 2/3325
танай _____-ны № _____-т

Танай 225 дугаар албан тоотын хариу

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ
Б. БАТБАЯР ТАНАА

Үндэсний аудитын газраас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны саналын дагуу хийсэн аудитын тайлангийн төсөлд дараах тайлбарыг хийж, төслөө эргэн харахыг хүсч байна. Үүнд:

Хууль зөрчин тендерт оролцуулсан байна гэсэн дүгнэлтэд хийх тайлбар:

1.3.

БСШУЯ Монгол Улсын Их Хурлын 2005 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусгагдсан англи хэлний сургалтын чанарыг сайжруулах, сургалтын чанар үр ашгийг нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээ, шаардлагыг тодруулах зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөлд ГХСТХ, МАХБНХ, Боловсролын хүрээлэн, Их, дээд сургуулийн багш, судлаачид, “Дайнед Монгол” ХХТ зэрэг англи хэлний боловсролын чиглэлээр ажилладаг байгууллагуудаас санал авсан болно. /Зөвхөн хөтөлбөрийн төсөлд санал авсан бөгөөд тендерийн материал боловсруулах, техникийн нөхцлийг боловсруулах үйл ажиллагаанд огт оролцуулаагүй бөгөөд, тендерийг нээлттэй зарласан болно/.

1.4.

Сонирхогч талуудын тендерт оролцох эрх нь “Зууны шуудан” /2007-11-08 №046/046 дугаар/ сонинд гарсан нээлттэй зараар хангагдсан гэж үзэж байна. “Нэпко” ХХК–г англи хэлний боловсролын чиглэлээр олон улсын хэмжээний байгууллагатай хамтран ажилладаг туршлагатай, хөтөлбөрийн гол үзэл санаанд нийцэх үйл ажиллагаа явуулдаг гэдэг утгаар урьсан байсан ба энэ компани хөтөлбөрийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд огт оролцоогүй болно. Эдгээр байгууллагууд тендерийн бичиг баримтад чухам ямар шаардлага, даалгаврыг үйлчилгээ үзүүлэгчдэд тавихыг мэдээгүй болно. Тийм ч учраас ZZ-2007-04 тендерт МАХБНХ–ноос ирүүлсэн саналд захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн санал ирүүлж, үнэлгээний хороо тендерийг хүчингүйд тооцсон байна.

1.5.

Энэхүү үйл ажиллагаа нь анх удаа зохион байгуулагдаж байгаа өвөрмөц үйл ажиллагаа юм. Хөтөлбөрийг боловсруулахдаа боловсролын талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгын үүднээс, англи хэлний боловсролын чиглээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, судлаач, иргэн, сонирхогч талуудын санал, англи хэлний багш нарын санал, зөвлөмж, дүгнэлтийг авах нь зүйтэй гэж БСШУЯ үзсэн. Монгол улсын хэмжээнд англи хэлний боловсролын чиглэлээр мэргэжлийн түвшний үйл ажиллагаа явуулдаг байгууллага, мэргэжилтний хүчин чадал хомс бөгөөд энэхүү үйл ажиллагаанд гадаадын мэргэжлийн байгууллагуудыг

оролцуулж байж олон улсын жишигт нийцсэн түвшинд англи хэлний боловсролын байдлыг үнэлж дүгнэх, мэргэжилтнүүдийг хөгжүүлэх, сургалтыг дэмжих ажлыг хийх шаардлагатай байгаа нь судалгаагаар харагддаг.

Үнэн зөв шалгаруулаагүй байна гэсэн дүгнэлтэд хийх тайлбар:

ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах ZZ-2007-01 тендерийн материалыг Сангийн Яам хянан үзэж “техникийн дүгнэлтийг үнэн зөв хийж чадаагүй” гэсэн үндэслэл гаргасан байгаа нь ерөөс тендерийг үнэн зөв шалгаруулаагүй байна гэсэн үг биш гэж үзэж байна. Мөн Авилгалтай тэмцэх газраас хийсэн шалгалтаар тендерийг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийн үйл ажиллагааг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзсэн болно.

Сургалтанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарын англи хэлний мэдлэг хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хийх тайлбар:

2.13

Сургалтанд хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарын англи хэлний мэдлэгийн түвшинг мэдээлэл харилцааны технологи ашиглан тогтоох шалгалтаар тэдний мэдлэгийн түвшин олон улсын жишигт хүрэхгүй байгаа явцын дүн гарсан нь сургалтанд мэдээлэл харилцааны технологи ашиглан англи хэл заах арга зүйг эрс дээшлүүлэх хэрэгцээ байгааг харуулж байгаа юм. Цаашид 6 сарын турш үргэлжлэн сургалтыг явуулахад эцсийн дүгнэлт өөр гарна гэж төлөвлөсөн болно. Тиймээс “Дайнед” ХХК аас явуулсан санал асуулгад багш нарын 98 % нь мэдээллийн технологи ашиглан англи хэл заах нь үр дүнтэй гэж хариулсан байна.

Хөтөлбөрийн дэвшүүлсэн зорилт өөрчлөгджээ гэсэн дүгнэлтэд хийх тайлбар.

2.19

Дээрх хөтөлбөрийн дагуу 2007-2008 оны хичээлийн жилд 11 дүгээр ангийн сурагчдыг хамруулж болох байсан боловч хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа / 6 сар/, үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг тооцоолох зорилгоор төгсөх ангиас бусад ангийн сурагчдыг хамруулахаар шийдвэрлэсэн байна.

2.20

Хөтөлбөрийн зорилтыг Монгол Улсын Их Хурлын 2005 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн **англи хэлний сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх** зорилтын өргөн хүрээнд авч үзсэн ба Монгол улсын 2007 оны төсөв, түүний тодотголд англи хэлний сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах төсөв нь урсгал зардал дотор туссан байгаа болно.

Гэрээний явцын хяналт дутмаг байна.

2007 оны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан англи хэлний лабораторийн хэрэгжилтийг шалгаж зааварчилгаа өгөх тухай Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн 107 тоот тушаалын дагуу нийслэлийн 1, 23, 31, 20, 51, 45, 2 дугаар сургуулиудад газар дээр нь хэрэгжилтийн байдалтай танилцсан болно.

Нийлүүлсэн компьютер, тоног төхөөрөмж нь тендерийн бичиг баримтад заасан шаардлагад нийцсэн үзүүлэлттэй байсан ба хөдөө орон нутагт нийлүүлж буй лабораторийг очиж үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Ажлын хэрэгжилтийн явцын мэдээг 2008 оны 3 дугаар сарын 31 ны өдрийн байдлаар MCS компаниас 1/208 дугаартай албан бичгээр авсан ба 6 дугаар сарын 1-ны байдлаар электрон хэлбэрээр мөн аваад байна.

MCS компаниас ирүүлсэн явцын тайлангийн мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА -с

A handwritten signature in black ink, appearing to be 'M. Mishiigjav'.

М. МИШИГЖАВ

БСШУЯ-наас ирүүлсэн саналд өгсөн тайлбар

Тайлбар: 1.3, 1.4, 1.5

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14.1.15-д “Тендерт оролцогч нь... бусад баримт бичгийг бэлтгэсэн,... зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой “ нь тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ гэж заасныг зөрчсөн гэж үзсэн учраас энэ тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар: Үнэн зөв шалгаруулаагүй байна

ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах ZZ-2007-01 тендерийн материалыг Сангийн Яам хянан үзэж “техникийн дүгнэлтийг үнэн зөв хийж чадаагүй” гэсэн дүгнэлтийг үндэслэлтэй байна гэж үзсэн тул тайланд тусгасан.

Тайлбар: 2.13

Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар: 2.19, 2.20

УИХ-аар хэлэлцэхэд оруулсан хөтөлбөрийн зорилт хөтөлбөр батлагдсаны дараа БСШУС-ын тушаал болон бусад баримт бичигт тусгагдаагүй өөрчлөгдсөн тул дээрхи дүгнэлтийг хийсэн болно.

Тайлбар: Гэрээний явцын хяналт дутмаг байна

ТНБД-ын тушаалаар “Англи хэлний сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх” ТТ-2007-27 тендерийн явцад хяналт тавих яамны ажлын хэсэг томилогдсон боловч гэрээний явцын хяналтын тайланг аудитын багт өнөөг хүртэл гаргаж өгөөгүй тул бид гэрээний явцын хяналт дутмаг байна гэж үзсэн.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологийн чиглэлээр англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах хөтөлбөрийн бараа, ажил, үйлчилгээний сонгон шалгаруулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2008 оны 12 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хоёрдугаар газрын захирал Ц.Батбаярт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

070357

Төсөл

